МОНГОЛ, ЯПОНЫ ХАРИЛЦАА: ЭРЭГ ХАНДЛАГА, ӨӨДРӨГ ҮЙЛ ЯВЦ

Л. Хайсандай

«Монгол Улс ба Зүүн хойт Ази (ная, ерээд оны чиг хандлага)» номын 8-р бүлгээс хэсэглэн авав.

Монгол, Японы харилцааг чухамдаа түүхийн үүднээс хөөж үзэхүл ене эртнийх бөгөөд уг харилцааны ул мөр нь хэдэн зууны тэртээд хамаарагдах бөлгөө.

Бие биерүүгээн тэмүүлэх шинж онцлог ямагт байсан авч нэг нэгэндээ үл итгэх бусадтай эвсэн сүлбэлдэж олон жилээр хэлхээ холбоогүй явж ирсэн зохисгүй явдал ч үе үе тохиолдож байв. Өөрөөр хэлбэл бидний Монгол, Японы харилцаа тэр бүр сайн сайхан хэвийн тогтвортой байсангүй.

Энэ бүх түүхийн асуудлыг энд эс өгүүлэн Монгол, Японы хоорондын орчин үеийн албан ёсны харилцааны өнөөгийн бодит байдал, үйл явцыг тоймлон авч үзсү.

Дэлхийн том гүрнүүд «Гадаад Монгол»-ын оршин тогтнох эрхийг хүлээн зөвшөөрч, улмаар 1945 оны 10 дугаар сард явагдсан бүх нийтийн санал хураалтаар Монголын ард түмэн тусгаар тогтнолоо нэгэн дуугаар санал нэгтэй баталсныг үндэс болгон Хятадын Засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг арга бүюу хүлээн зөвшөөрч 1946 онд дипломат харилцаа тогтоосон зэрэг олон хүчин зүйл нь Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтоох суурийг тавьсан гэж болно. Японы Засгийн газар чухамхүү энэ бодит байдлыг зөв үнэлж, 1961 онд манай улсыг НҮБ-д гишүүнээр элсэхэд саналаа өгсөн нь үнэн хэрэгтээ манай улсыг де фактаар хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Дэлхийн том гүрнүүд 1961—1971 оны хугацаанд Монголтой дипломат харилцаа ихэнхдээ тогтоосон атал Ази тивд орших Монгол, Япон хоёр энэ үед дипломат харилцаагүй байлаа. Энэ нь дараах учир шалгаантай байв.

Манай тал Японоос дайны төлбөр нэхэж, Японы тал Монголтой дайн хийж байгаагүй, төлбөр төлөхгүй гэж 11 жил маргалдсаар харилцан ойлголцох байдалд хүрч чадалгүй 1972 он хүргэжээ. Зөвхөн 1972 оны 2-р сарын 24-нд дипломат харилцаа тогтоосон билээ. Ийнхүү манай хоёр улс анх удаа албан ёсны харилцаа тогтоосон нь тус хоёр орны эрх ашигт бүрнээ нийцсэн ба эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэхэд тус дөхөм болсон билээ. Энэ талаар хоёр засгийн газрын хоорондяваг дсан хэлэлцээрийн явцад Японы тал дайны төлбөр гэдэг нэрээр бус, хамтын ажиллагааны хэлбэрээр Монголд зохих хэмжээний хөрөнгө өгөхийг мэдэгдсэнээр харилцан ойлголцолд хүрсэн учир БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид Японтой дайны байдлыг зогсоох тухай зарлигийг 1972 оны 2-р сарын 11-нд гаргасан байна.

---

* Л. Хайсандай. ЗХАСТ-ийн тэргүүлэх ажилтан, дэд доктор

Хоёр тал эхний удаад Москвад суугаа Элчин сайд нараа хавсран ажиллах элчин сайдаар томилохоор тогтож, манай элчин сайд Н. Лувсанчүлтэм 1972 оны 6-р сард Японы эзэн хаанд итгэмжлэх жуух бичгээ гардуулсан бөгөөд Японы элчин сайд К. Ниисэки 1972 оны 8-р сард БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн даргад итгэмжлэх жуух бичгээ барьснаар хоёр орны харилцааны шинэ хуудас албан ёсоор нээгдсэн юм. Энэ бол Монгол-Японы харилцааны 700-гаад жилийн түүхэн дэх анхны чухал үйл явдал байлаа (1).

Монгол-Япон хоёр улс аль аль нь харилцаагаа цааш нь улам бэхжүүлэн хөгжүүлэх эрмэлзэлтэй байсан тул тус тусын оронд Элчин сайдын яамдаа нээх болов. Япон улс Монголд суух элчин сайдын яамаа 1973 оны 6-р сард нээсэн бөгөөд байнга суух элчин сайд Итару Цугээ 10-р сард хүрэлцэн ирж ажилдаа оров.

Японд ажиллах манай элчин сайдын яамны зөвлөхөөр томилогдсон Л. Чулуунбаатар тэргүүтэй баг Токиод хүрэлцэн очиж элчин сайдын яамаа 1973 оны 12-р сарын 24-нд нээсэн бөгөөд байнга ажиллах элчин сайд С. Дамбадаржаа 1974 оны 1-р сарын 10-нд Токиод очиж 1-р сарын 31-нд Япон улсын эзэн хаан Хирохитод итгэмжлэх жуух бичгээ барин үүрэгт ажилдаа оржээ. Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд, Японд тогтсон заншлаар эзэн хаан ба хатан гадаадын Элчин сайд, түүний гэргийг Японд ажиллах 3—4 жилийн хугацаанд нь нэг л удаа ордондоо урьж зоог барьдаг зуршилтай атал Монголын элчин сайдыг Японд очсоноос хойш тун удалгүй 1974 оны 10-р сарын 1-нд гэргийнх нь хамт зоогонд урьж, зэрэгцэн суугаад найрсгаар ярилцсан байна (2). 1972 оны 4-р сарын 5-нд Монголын элчин сайд Японы Гадаад явдлын Яамны орлогч сайд Хогэнтой уулзаж еерийн Гадаад яамны нот бичгийг гардуулжээ. Энэ бичигт дипломат харилцаа тогтоосноор хоёр орны харилцаа хөгжих боломж нээгдсэнийг тэмдэглээд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх хэлэлцээрийг Засгийн газрын төвшинд Токиод юм уу Улаанбаатарт явуулах, хоёр талдаа худалдааны үлэмж таатай нөхцөл бүрдүүлэх, соёл, шинжлэх ухаан, техникийн харилцаагаа хөгжүүлэх, Японы талаас Монголын ард түмний өмнө санаа сэтгэлийн үүрэг хүлээх (Дайны төлберийг хэлж байна) талаар урьд тохиролцсоны дагуу тодорхой хэмжээний буцалтгүй хөрөнгө олгох, тэр хөрөнгөөр Монголд зарим үйлдвэр байгуулахыг санал болгосон байна. Ямааны ноолуур, тэмээний ноосон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ноосон утас ээрэх, ангийн үс боловсруулах, чулуу, цонхны шил, шилэн лонхны үйлдвэр, зочид буудал зэрэг 15 үйлдвэр объектын жагсаалтыг уг нот бичигт хавсаргасан байлаа. Японы тал манай саналыг судлан үзэх болжээ. Элчин сайдын яам ч Японы Засгийн газрын байгууллагууд, хувийн пүүсүүдтэй холбоо тогтоож, тэдэнд эх орныхоо байдлыг ойлгуулах, дэмжлэг авах талаар тодорхой ажиллагаа явуулжээ.

1974 оны 8-р сард Японы Гадаад явдлын Яамны Азийн товчооны дарга Такашима тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатарт ирж хэлэлцээ хийсний дунд Японы тал цөөн тооны

үйлдвэр байгуулахад зориулан хөренгө гаргах Төлөв тодорхой болсон тул манай тал гурван үйлдвэр байгуулахад Японыг оролцуулах саналаа 1975 онд тавьсан байна.

Монгол-Японы худалдаа 1960-аад оноос эхэлж бага боловч жил тутам өсөж байсан бөгөөд Японы тал 1974 оноос манай хөдөө аж ахуйн гаралтай бараанд гаалийн хөнгөлөлт үзүүлэх болсон нь худалдааны өсөлтийг хэмжсэн нэгэн чухал арга хэмжээ байлаа. Манай тал үлэмж тааламжтай нөхцөл бие биедээ бүрдүүлэх заалт бүхий худалдааны хэлэлцээр байгуулах саналаа дэвшүүлж, төслөө 1974 оны 6-р сард Японы талд гардуулснаас хойш хоёр тал өөр өөрийн теслийг хэд хэдэн удаа солилцсон боловч тохиролцож чадаагүй хойшлогдов. Монголын талаас олон жил дараалан хатуу шаардаж ирсэн дайны төлбөрт тийм нэрээр бус, буцалтгүй тусламжийн хэлбэрээр хичнээн хөренгө гаргахаа Японы тал нарийн дэнсэлж байв. Ингэж хөренгө олгох нь нэгд, эдийн засгийн хамтын ажиллагааны эх суурийг тавихад хэрэгтэй, хоёрт, Монголын байгалийн баялгийг цаашид хамтран ашиглах бололцоотой болох байв. Үүний хажуугаар Монголтой харилцаа хөгжүүлэхэд ЗХУ саад хийх эсэх, Орос, Хятадын хооронд хавчуулагдан орших Монголтой харилцахад зам, тээвэр, харилцаа холбооны бэрхшээлийг хэрхэн давах зэрэг асуудал гарч байв.

Монгол-Японы харилцаа улс төрийн салбарт дорвитой хөгжиж чадахгүй гэдэгт ЗХУ итгэж байсан боловч эдийн засаг, худалдааны салбарт хөгжиж болзошгүй байгаад сэжиглэлтэй хандаж Японыг гүнзгий оруулж болохгүй, ЭЗХ ТЗ-ийн орнуудтай л хамтран ажиллах хэрэгтэй гэдэг зөвлөгөө өгч байсан юм. Манай тал ч батлан хамгаалах ба аюулгүйн байдлын учир шалтгаанаар Японтой далайцтай хамтран ажиллахгүй гэдгээ Зөвлөлтийн талд итгэлтэйгээр мэдэгдэж байлаа. Жишээ нь, Цагаансуваргын зэсийн орд газрыг хамтран ашиглахыг Японы пүүсүүд сонирхож, тэнд хийгдэх геологи хайгуулын ажил, техник, эдийн засгийн үндэслэлийг гаргах, зардлыг ч даах талаар саналаа дэвшүүлж эхлэхэд нь манайхан анхандаа сүрхий зөвшөөрч байснаа Зөвлөлтийн талтай зөвлөлдсөний дараа татгалзаж япончуудын урмыг хугалан, гайхлыг төрүүлж байсан билээ. Дайны төлбөртэй холбогдсон эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээ яриа үргэлжлэхийн зэрэгцээ улс төр, соёлын харилцаа нааштай урагшилж байв. Тэгэхдээ хийгдэх алхмуудын ихэнх нь Японы талын санаачилгаар бүтэж байсан юм (3).

Хоёр Гадаад яамны хооронд харилцааны шугамаар 1974 оноос эхлэн Японы талын төлөөлөгч жил бүхэн ирэх болсон бөгөөд 1975 оноос манай Гадаад яамны төлөөлөгч айлчилдаг болов. Тухайлбал 1974 оны 9-р сард Японы парламентын дээд танхимын гишүүн М. Кимура тэргүүтэй анхны төлөөлөгч манайд айлчилсан бөгөөд 1975 онд Дээд танхимд Япон-Монголын найрамдлын бүлэг 47 гишүүнтэйгээр байгуулагдав. 1977 онд манайд Монгол-Японы парламентын бүлэг байгуулагдаж, улмаар Ардын Их Хурлын те-

лөөлөгч Японд анх удаа айлчилсан билээ. 1978 онд Японы парламентын төлөөлөгчдийн танхимд 51 гишүүн бүхий Япон-Монголын найрамдлын бүлэг байгуулагдаж парламентын 2 танхимын 3 намын гишүүнээс бүрдсэн том төлөөлөгчид 1978 онд манайд айлчилж, 2 орны харилцааны цаашдын төлөвийн талаар саналаа солилцсон нь бие биеэ ойлгоход тус нөлөөтэй ажил болсон юм. Японы тал манайхаас аль болох өндөр түшаалтныг урьж зочлох чиглэл баримтлаж, Гадаадтай эдийн засгийн харилцаа эрхлэх улсын хороны дарга, ЭТНБХГХ-ны дарга, ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд, сайд нарыг удаа дараа урьж байсан боловч манайх явуулахгүй хойшлуулж байсан нь хойд хөршөөсөө эмээж байснаас болсон биз ээ.

1974 оноос соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах Засгийн газруудын хэлэлцээр байгуулагдаж, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг жил бүхэн тохиролцон, оюутан, аспирант, мэргэжил дээшлүүлэх хүмүүс, хэлний багш нарыг солилцох, кино үзэсгэлэн урлагийн бүлэг харилцан илгээх зэргээр хамтран ажиллах болов. Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-тэй холбоо тогтоож, Тэдний зардлаар инженер-техникийн хүмүүсийг Японд явуулж дадлага хийлгэх, хөдөө аж ахуйн бага оврын техник тоноглол, эмнэлгийн багаж хэрэгсэл авах зэрэг хамтын ажиллагааны эхлэл тавигдав.

Энэ мэтээр япон, монгол хүмүүс харилцан зочлох нь олширч, нэг нэгнийхээ тухай нэлээд мэдээлэлтэй болж, харилцан ойлголцох нь ахисны үндсэн дээр эдийн засгийн хамтын ажиллагааны анхны хэлэлцээр байгуулагдах боломж бүрдсэн юм. Японы ГЯЯ, Сангийн яамныхан Монголд олгох буцалтгүй хөрөнгийг 10 сая. ам. доллараас ахиулж өгөхгүй байсан тул Тэр үед Ерөнхий сайд байсан Фукудатай Монголын элчин сайд С. Дамбадаржаа уулзаж учир байдлаа тайлбарлаж ярилцахад «Танайх шаардлагаа багасга, манай тал өгөх хэмжээгээ нэмье» гэж мэдэгдсэн байна (4). Ийнхүү таван жил хэлэлцсэний дараа жилдээ 1000 тонн ямааны ноолуур, 200 тонн тэмээний ноос боловсруулж бэлэн бүтээгдэхүүн хийх үйлдвэр байгуулахад зориулан 5 тэрбум иен (тэр үеийн ханшаар 17 сая ам. доллар)-ийг Японы тал буцалтгүй олгох хэлэлцээр 1977 оны 3-р сарын 17-нд Улаанбаатар хотноо байгуулсан юм. Дээрх хөрөнгийг ашиглан уг үйлдвэрийг байгуулах контрактыг Японы Иточу пүүстэй 1978 оны 5 дугаар сарын 15-нд байгуулснаар Монгол-Японы барилгачид ажилдаа оров. Үйлдвэрийн барилгыг манай тал өөрийн зардлаар барьсан бөгөөд барилгын зарим төмөрлөгэд ангийг оролцуулан үйлдвэрийн бүх техник тоноглолыг Японы тал нийлүүлж инженер-техникчдээ ажиллуулан, үйлдвэрт ажиллах монгол хүмүүсийг Японд сургасан юм. Энэ үйлдвэр 1981 онд хугацаандаа ашиглалтад орж «Говь» комбинат нэртэй болсон бөгөөд дэлхийн зах зээлд борлогдож чадах чанартай бүтээгдэхүүн гаргадаг манай анхны үйлдвэр болж, тус орны хатуу валютын орлогын нэлээд хувийг хангаж байна. «Говь» комбинат бол Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны алтан хараацай бөгөөд хоёр орон

үр ашигтай хамтран ажиллаж болохын сайхан нотолгоо болсон билээ гэж элчин сайд С Дамбадаржаа дурсан бичжээ. (5). Өнөө үед энэ үйлдвэрт нэг ч япон мэргэжилтэн үгүй, монголчууд бие даан ажиллаж байна. Тийнхүү 1980-аад оны дунд үеэс эхлэн манай хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг, соёлын бүх салбарт улам өргөжин хөгжих боломж нээгдэв.

Энэ үйл явцад хуучин ЗХУ-д өөрчлөн байгуулалт, эхэлж, гадаад харилцаанд нь улс төрийн шинэ сэтгэлгээний үзэл санаа хэрэгжин, Зөвлөлт-Америкийн харилцаа сайжирч, манай оронд өөрчлөлт шинэчлэлтийн бодлого явагдан, дэлхийн улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөтгөн тэлэх болсон нь чухал түлхэц өгсөн бөгөөд Монгол-Японы харилцаанд шууд тусгалаа олов. 1980-аад оны эцсээс Монгол-Японы харилцаа идэвхжиж ирлээ. 1987 онд манай ГЯЯ-ны сайд Японд анх удаа, 1989 онд Японы ГЯЯ-ны сайд манайд айлчлав. Энэ бол өндөр хөгжилтэй орны ГЯЯ-ны сайд Монголд хийсэн анхны айлчлал болсноороо чухалд тооцогддог билээ.

Манай Засгийн газар Япон улстай эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн харилцаагаа идэвхтэй хөгжүүлэх бодлого баримталж, улсын төлөвлөгөөний хорооны нэгдүгээр орлогч дарга, төрийн сайд Т. Намжим тэргүүтэй төлөөлөгчдийг 1988 онд Японд илгээж, өргөн хүрээтэй асуудлаар санал бодлоо солилцсон юм.

1990 оны 2-р сард Сайд нарын Зөвлөлийн дарга Д. Содном Японд айлчилж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх асуудлаар төр, засгийн газар, эдийн засгийн байгууллагуудын удирдагчидтай саналаа солилцож манай талаас Японтой ямар салбарт хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлсэн билээ. Энэ үеэр хоёр орны Засгийн газрын хооронд худалдааны хэлэлцээр байгуулсан байна. Энэ бол манай засгийн газрын тэргүүн өрнөдийн өндөр хөгжилтэй оронд анх удаа хийсэн айлчлал болсноороо онцлогтой бөгөөд Японтой байгуулахаар 1970-аад онд таван жил дараалан ярилцаад тохирч чадаагүй байсан худалдааны хэлэлцээр сая биелэлээ олж байгуулагдав.

1989 оны 2-р сард Японы эзэн хаан, талийгаач Хирохитог оршуулах ёслолд БНМАУ-ын Ардын Их Хурлын дарга оролцсоны дээр 1990 оны 11-р сард хунтайж Акихитог эзэн хааны ширээнд залах ёслолд БНМАУ-ын Ерөнхийлөгч П. Очирбат оролцсон нь манай Засгийн газраас Япон улсад найрсгаар хандах болж, энэ оронтой харилцаагаа идэвхтэй хөгжүүлэх бодлого баримталж буйн илрэл болов. Мөн 1992 онд Ерөнхий сайд асан Бямбасүрэн, 1993 оны 11 дүгээр сард П. Жасрайн албан ёсны ажлын айлчлалт, 1994 оны 10 дугаар сард УИХ-ын дарга Н. Багабанди тэргүүтэй төлөөлөгчид, 1995 онд Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэнгийн албан айлчлал тус тус болсны зэрэгцээ бусад өндөр хэмжээний олон арван төлөөлөгчид Япон улсад удаа дараа зочилжээ.

1991 оны 8-р сард Япон улсын Ерөнхий сайд Тошики Кайфу манайд албан ёсны айлчлал хийсэн нь дэлхийн өн-

дөр хөгжилтэй том орны Засгийн газрын тэргүүний анхны айлчлал болов. Энэхүү айлчлал хоёр орны харилцааг шинэ шатанд гаргаж хөгжүүлэх зориг хоёр талаасаа ирмүүн байгаагийн илрэл болсон юм. Хэлэлцээний үеэр хоёр орны харилцааг XXI зуунд чиглүүлж хөгжүүлэх нэгдсэн зарчмыг тодорхойлж, найдвартай суурь тавих зорилгоор ойрын үед авах арга хэмжээг тохиролцсон билээ. Эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид гурван үе шаттайгаар хөгжүүлэх, үүнд ойрын үед Монгол орны эдийн засгийн хямрал бэрхшээлийг даван туулахад тусламж үзүүлэх, Монголыг дэмжигч орнуудын үйл ажиллагаанд Японы тал зохицуулахаар тохиролцсон юм. Дунд үеийн хамтын ажиллагаа манай орны эдийн засгийн дээд бүтцийг шинэчлэх чиглэл, тухайлбал Интелсат газрын станцыг байгуулахад буцалтгүй тусламж үзүүлэх зэрэг асуудал оров. Урт хугацааны хамтын ажиллагаанд эдийн засгийн өндөр хөгжилтэй, техник технологи хүчирхэг хөгжсөн Япон улс, байгалийн асар их нөөцтэй манай орон хоёр хамтран ажиллах асуудлыг тусгажээ.

Хоёр орны удирдагчид ноён Кайфугийн манай оронд хийсэн айлчлалыг хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны цоо шинэ үеийг нээсэн, XXI зууны ажиллагааны эхлэлийг тавьсан үйл явдал гэж санал нэгтэй үнэлсэн билээ.

Эдүгээ манай хоёр орны хамтын ажиллагаа олон салбарт амжилттай хөгжиж байна. Үүнд: Монгол-Японы хамтарсан «Гурван гол» төслийн дагуу Чингис хааны булшийг эрж хайх ажил 1990 оноос эхлэн явагдав. Монголын бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг судлах, цаашид боловсронгуй болгох, хөдөөгийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх хамтарсан судалгааны ажлын «Говь» төслийг Монгол-Японы эрдэмтэд хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ. Дорнод ба өмнөд аймгуудын хөрсөн доорх байгалийн эрдэс баялгийг судлах, хайх ажлыг хамтран гүйцэтгэх 3 жилийн хугацаатай «Уудам тал» хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Японы Засгийн газар 2 сая гаруй долларын хөрөнгө гаргаж, уг ажил өрнөж байна. Дархан хотод Японы санхүү техникийн тусламжаар төмөрлөгийн үйлдвэр барьж дуусгасан байна. Энэ бүхэн хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд өргөн боломжийн эхний алхам болон орно. Тийнхүү Япон улс манай өөрчлөлт, шинэчлэлийг эхнээс нь идэвхтэй дэмжиж улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн сэтгэл харамгүй тусламж үзүүлж байна. Энэ дэмжлэг тусламж нь Монгол дахь ардчилсан үйл явцыг бэхжүүлэх, шилжилтийн үеийн эдийн засгийн хүндрэлийг хөнгөвчилж цаашдын хөгжлийн шинэ суурийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болж байгаа юм.

Япон улсаас манайд үзүүлж буй тусламж жилээс жилд нэмэгдэж агуулга, ач холбогдол нь улам гүнзгийрсээр, эдийн засаг, аж ахуйн амьдралын бүх хүрээг хамран өргөжиж байна.

Япон улсын Засгийн газраас 1990 онд 494 сая иений төслийн буцалтгүй тусламжаар эмнэлгийн тоног төхөөрөмж болон МУИС-ийн номын сангийн тоног төхөөрөмж нийлүүлж эхэлсний зэрэгцээ техникийн туслалцааны шугамаар 151 сая иений тусламж үзүүлжээ.

1991 онд 3,4 тэрбум иений төслийн буцалтгүй тусламж үзүүлж, тухайлбал, эдийн засгийн бүтцийг сайжруулах төслийн хүрээнд Интелсат системийн газрын хүлээн авах станц байгуулж эхэлсний зэрэгцээ Улсын филармонд хөгжмийн зэмсэг нийлүүлэх, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тусламж олгосон байна. Түүнчлэн техникийн туслалцааны хүрээнд хүн сургах, зөвлөх мэргэжилтэн ирүүлж ажиллуулах, хөгжлийн судалгаа хийх зэрэгт 420 сая иений тусламж олгосон байна.

Энэ оноос эдийн засаг, аж ахуйн үйл ажиллаганы нэн яаралтай хэрэгцээг хангахад зориулж 4,84 тэрбум иений урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн байна.

1992 онд 3,98 тэрбум иений буцалтгүй тусламж үзүүлж Сансрын холбооны «Интелсат» газрын станцын хоёрдугаар эзлж, Улаанбаатарын IV цахилгаан станцын засварын эхний эзлжийн төслийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Мөн хүнсний бараа нийлүүлэхийн зэрэгцээ хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тусламж үзүүлсээр байна.

Хүн сургах, мэргэжилтэн зөвлөх ирүүлэх, залуучуудын сайн дурынхныг илгээх, хөгжлийн судалгаа хийх зэрэг техникийн туслалцаа үзүүлсэн ба үзүүлж байна.

1993 онд 1,3 тэрбум иений төслийн буцалтгүй тусламж олгож, IV цахилгаан станцын засвар, эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Холбооны салбарт тоног төхөөрөмж нийлүүлэх «Интелсат» төслийг хэрэгжүүлснээр Монгол улс сансрын холбооны системд холбогдож дэлхийн өнцөг булан бүртэй саадгүй харилцдаг болсон юм.

Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд Улаанбаатар, Дархан хотын 9 эмнэлэг, 7 аймгийн 42 сумын эмнэлгийг орчин үеийн зарим техник, тоног төхөөрөмжөөр тоноглосон. Үүний зэрэгцээ хүнсний бүтээгдэхүүн, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тоног төхөөрөмж, байгалийн гамшигтай тэмцэх арга хэмжээнд зориулж тусламж үзүүлэв.

1994 онд IV цахилгаан станцын II эзлжийг дуусган Замын-Үүдэд шилжүүлэн ачих байгууламж барих төслийг хэрэгжүүлж ашиглалтанд оруулав. Төмөр замын тээх нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх төслийн нийт өртөг нь 71 сая ам. доллар бөгөөд энэ төсөл нь хоёр үе шаттайгаар үргэлжлэн хэрэгжив. 1995 онд Улаанбаатар хотын нийтийн тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн I эзлж (60 автобус), Дарханы мах комбинатын хөргөлтийн систем, Улаанбаатарын сүүний үйлдвэрийн хөргөлтийн систем, хөдөө аж ахуйн машин техникийг шинэчлэх, «Байгалийн битүүмжилсэн чулуулгыг зам барихад ашиглах» төслийг хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлж эхлээд байна.

Хамтын ажиллагааны хүрээнд өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ цаашдын дэмжлэг тусламж, туршлага, техник технологид тулгуурлан бүхэлд нь шийдвэрлэх зарчим баримтлан хөгжлийн судалгааг хийж байна. Энэ хүрээнд «Уудам тал», «Цав» төслүүд, Улаанбаатар хотын ус хангамжийн

хайгуул, Удаанцавын районы топографийн зураглал зэрэг хөгжлийн судалгаа явуулж, хүн сургах, зөвлөх мэргэжилтэн ирүүлж ажиллуулах ажлыг зохион байгуулж байна. 1994 оноос Монголын нүүрсний уурхайг хөгжүүлэх, нүүрсийг зохистой ашиглах, Монгол орны Төвийн бүсийг хөгжүүлэх, «Алтан тал», Алтай хотын усан хангамжийн төслийн судалгааг эхлээд байна.

Хөгжлийн судалгааны хүрээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үр ашигтай арга зам, механизмыг боловсруулан гаргадаг бөгөөд энэ нь цаашдын хамтын ажиллагааны томоохон төслийг хэрэгжүүлэх бэлтгэл болж өгдөгөөрөө онцлогтой юм.

Япон улсын сайн дурын нийгэмлэгийн шугамаар залуу мэргэжилтэн томилон ажиллуулах тухай хоёр Засгийн газрын хооронд «нот» солилцож, 1992 онд өөрийн төлөөлөгчийн газраа манай улсад нээснээс хойш манай их сургууль, үйлдвэр аж ахуйн газар, ерөнхий боловсролын сургууль, олон нийтийн байгууллагад нийт 26 залуу мэргэжилтэн ирж ажиллаж байна. Мөн Японы Менген сайн дурынхны нийгэмлэгийн шугамаар анхны мэргэжилтэн ирж япон хэлний багшаар ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хэлбэр, зээл, тусламжийн зориулалт, бүтцийг авч үзвэл эхний үед бараа, яаралтай худалдан авах нэн, шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх явдал зонхилж байсан бол одоо урьдчилан судалгаа хийж тохирсон төсөл арга хэмжээ, дэд бүтцийг хөгжүүлэх тэргүүн ээлжийн асуудалд түлхүү чиглэж байна.

Монгол, Японы эдийн засгийн харилцаа ийнхүү манай эдийн засгийн бүтцийг өөрчлөх, үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтцийг шинэчлэх, эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийн төлвийг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх зэрэг өргөн хүрээтэй зорилтуудыг хамрах болсон нь уг хамтын ажиллагаа ихээхэн цогцолбор шинж чанартай болж байгааг нотолж байна. Энэ нь манай хоёр орны эдийн засгийн харилцааны онцлог, Монголын хөгжилд Япон улсын оруулж буй бодитой хувь нэмэр мөн (6).

Японы Засгийн газар манай оронд өрнөж буй өөрчлөлт шинэчлэлийг дэмжиж, санхүү, эд материалын тусламж үзүүлэхийн зэрэгцээ Монгол улсыг дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд нэгдэн орох, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагад гишүүнээр элсэх, хандивлагчдын анхаарлыг Монгол улсад хандуулах, Монголд хандивлагч орнуудын уулзалтыг зохион байгуулах зэргээр Монгол улсыг олон улсын тавцанд идэвхтэй дэмжиж байна.

Монголыг дэмжигч орнуудын уулзалтыг Японы Засгийн газар анх санаачлан Дэлхийн банктай хамтран Токио хотноо 1991 оноос эхлэн 4 удаа зохион байгуулсан бөгөөд 5 дахь хурлыг 1966 оны 2 дугаар сар хийв. Энэхүү уулзалтуудаар хандивлагч орнуудаас Монголд жишээлвэл 1993 оны 150—175 сая ам. долларын зээл тусламж олгосон бол 1996 онд 290 гаруй сая ам. доллар болж өсчээ. Монголд хандивлагчдын хөдөлгөөн өрнөсөн 1991 оноос хойш Япон нь нийт 200 гаруй сая долларын (ашигласан тусламжийн дүн-

гээр) зээл, тусламж үзүүлээд байгаагийн 60 гаруй хувь нь буцалтгүй тусламж юм. Япон улс Монголд үзүүлж байгаа зээл, тусламжийн хэмжээгээр хандивлагч орнуудын дотор тэргүүлж байгаа бөгөөд дангаараа нийт зээл, тусламжийн 30 гаруй хувийг олгож байна. Тухайлбал, зөвхөн 1993 онд 44,7 сая ам. долларын буцалтгүй тусламж үзүүлж, 1993—1994 онд 41 сая ам. долларын хөнгөлттэй зээл олгожээ.

Японоос тусламж авдаг орнуудын дотор Монгол улс нэг хүн амд ногдох тусламжийн хэмжээгээрээ үлэмж дээгүүр орж байна.

Энэ бүгд нь ардчилсан өөрчлөлт шинэчлэлийн явцад нээлттэй болсон, түүх, соёл, уламжлалын хувьд уялдаатай Монгол улсыг харьцангуй богино хугацаанд хямралыг гэтэлж бие даасан хөгжлийн замд шилжих чадвартай болгоход Япон улсаас ихээхэн хүчин чармайлт гаргаж туушгай дэмжиж байгаагийн илрэл мөн.

1993 оны VII сард Токиод болсон дэлхийн «Том долоо»-гийн уулзалтын эдийн засгийн тунхаглалд: «Монгол зэрэг шилжилтийн үед байгаа орнуудтай тэдний шинэчлэлт, өөрчлөлтийн төлөө хүч чармайлтыг дэмжих зарчим болон хамтран ажиллах зарчим дээр тулгуурлан туслана гэдгээ дахин илэрхийлж байна» гэж онцлон тэмдэглэсэн билээ.

Японы Засгийн газрын хоёр талын болоод олон талын шугамаар гаргасан санаачилга, идэвхтэй үйл ажиллагаа нь манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны онцлог, агуулгыг үндсэнд нь тодорхойлж байгаа юм.

Монгол, Японы хамтын ажиллагаа нь дэлхийн тэргүүний эдийн засагтай хөгжингүй орон, шилжилтийн шатанд байгаа жижиг орны харилцаанд бий болсон шинэлэг, онцгой хэлбэрийг өөртөө агуулж байна. Бид энэ харилцааг зөвхөн зээл, тусламж олж авах арга зам гэж ойлгох учиргүй бөгөөд хоёр талд харилцан ашигтай, олон улсын харилцаа, азийн орнуудын харилцаанд өөрийн байр суурьа олсон зохих нөлөө, жин бүхий хамтын ажиллагаа болгохыг л зорих учиртай (7).

Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжил, хамтын ажиллагаанд Монгол улс эрх тэгшээр идэвхтэй оролцох зорилтыг хэрэгжүүлэхэд Япон улсын дэмжлэг, туршлага онцгой ач холбогдолтой юм. Хэдийгээр Монгол, Японы хөгжил, үйлдвэрлэл техник, технологийн түвшин, эдийн засгийн чадавхи нь зөрүүтэй боловч бие биеэ нөхөн тэтгэх боломж, хоёр талын сонирхлын хүрээ улам тэлсээр байгаа нь бодитой үйл явц юм.

Түргэн хурдацтай хөгжиж байгаа эдийн засгийн хамтын ажиллагааг улам бүр цогцолбор шинжтэй болгож, цаашид Монголын эдийн засгийн бүтцийг төгөлдөржүүлэх, үйлдвэрлэлийн дэд бүтцийг шинэчлэж өргөтгөх, хөдөөгийн нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, боловсон хүчнийг бэлтгэхэд илүүтэй чиглүүлэх нь зүйтэй мэт санагдана.

Энэ нь юуны өмнө зах зээлийн механизмыг бүрэн төлөвшүүлэх, оюун ухаан, технологийн мэдлэг өвлөн авах, боловсон хүчнээ шинэ зорилгод нийцүүлэн бэлтгэх, давтан

сургах, хүний хүчин зүйлийг дүүрэн ашиглах бололцоо олгоно.

Манай эдийн засгийн хамтын ажиллагааны томоохон түнш, хамгийн том хандивлагч Япон улстай цаашид хамтран ажиллах ерөнхий чиглэл, гол хандлагыг урт хугацаанд тодорхойлж дэс дараатай хэрэгжүүлэх зорилгоор хөгжлийн судалгааг хамтарч хийх, хөгжлийн ерөнхий бодлогыг Японы загвар, туршлагад тулгуурлан боловсруулж хэрэгжүүлэхэд анхаарал төвлөрүүлж байна. Монгол орныг зах зээлийн эдийн засгийн удирдлагын туршлага, өнөөгийн хөгжил, менежментийн онцлогийг анхааралтай судлах нь чухал ач холбогдолтой болж байна.

Хамтын ажиллагааны төслийг судалж боловсруулах, шийдэх, тодорхойлоход тодорхой хэмжээний ахиц гарч байгаа ч түүнийг шийдсэний дараа гэрээ, хэлэлцээрээр хүлээх үүргээ нарийвчлан биелүүлэх, техникийн баримт бичгийг бэлтгэхэд ихэвчлэн манай талаас үүдэлтэй хүндрэл бэрхшээл тохиолдсоор байна. Зээл, тусламжийг ашиглах, зохицуулах ажилд эзрим ахиц байгаа ч зохих түвшинд хүрээгүй байна.

Хэрэгжсэн төслийн үр өгөөжийг дээшлүүлэх, ялангуяа ашиглалтад хүлээн авсны дараахь ашиглалт хяналт, зохицуулалтыг сайжруулахад анхаарал төвлөрүүлэх нь зүйтэй байгаа юм.

Манай хоёр орны Засгийн газар хоорондын харилцаа улам ергөжиж, Засгийн газрын Ерөнхий сайд нар харилцан айлчилдаг уламжлал тогтоод байна. Өндөр хэмжээний ийм айлчлалууд нь хоёр орны харилцааны найрсаг уур амьсгалыг гүнзгийрүүлж, үйл ажиллагааг бататгах, харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны агуулга чиглэлийг тохиролцоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Японы хувийн үйлдвэрийн эздийн холбоо, эдийн засгийн зв санааны буюу Японы корпорациудын гүйцэтгэх удирдагчдын нийгэмлэг, банкны нийгэмлэгүүдийн холбоо зэрэг байгууллагуудтай холбоо тогтоосон нь хамтын ажиллагааны чухал эхлэл болж байна. Японы худалдааны томоохон пүүсүүд манай орныг сонирхох болж Японы Засгийн газрын хөгжлийн тусламжийн (ОДА) төслийг хэрэгжүүлэхэд оролцох, улмаар тодорхой салбарт хамтран ажиллахыг эрмэлздэг болж байна. Манай улс одоо Японы Иточу, Нишшё-Ивай, Мицубиши хэви индарстри. Сони, Сумитомо, Осака Кашмир, Марубэни, Ямаха, Юничка зэрэг 60 гаруй пүүстэй худалдаа эдийн засгийн харилцаатай болоод байна. Эдгээрээс Иточу, Сумитомо, Ямаха. Осака, Кашмир, Нишшё-Ивай, Ничимэн, Марубэни зэрэг олон пүүс төлөөлөгчийн газраа Улаанбаатарт нээгээд байна.

«Дайника» пүүс Япон тосгон байгуулах, Момури мужийн Шарики тосгон тал нутагт газар тариалан хөгжүүлэх, цагаан будаа тариалах төсөл боловсруулаад хэрэгжүүлж эхэлж байна.

1996 оны хавар Монгол оронд гарсан түймрийн сүйрэлд зориулж Японы засгийн газар 100 мянган ам. долла-

рын яаралтай тусламж үзүүлж, бусад нэн шаардлагатай арга хэмжээ авсан билээ.

Японы Засгийн газрын тусламжийн энэ мэтийн хамтын ажиллагаанаас гадна хувийн фонд, сангийн шугамаар хамтыа ажиллагааны хүрээ өргөжиж байна. Японы Сасакавагийн Энхтайвны сан 500 сая иений (8 сая орчим ширхэг нэг удаа хэрэглэх тариур. зүү) буцалтгүй тусламж олгов. Мөн Сагавагийн олон улсын хамтын ажиллагааны фондын шугамаар манай улсад засвар үйлчилгээ хийж сэргээгдсэн ачааны 100 авто машин 1991—1995 онд бэлэглэхээр амлаж ирүүлсээр байгаагийн зэрэгцээ Японы Шиохаку нийгэмлэг 1992 оноос Монгол бичгийг сэргээхэд зориулж жил тутам 10 сая иений хандив өргөж байлаа (8).

Түүнээс гадна сүүлийн жилүүдэд иргэд хоорондын төрөл бүрийн хэлхээ холбоо идэвхитэй өргөжих болов.

Тэгээд ч 1993 онд Монгол, Япон улс агаарын харилцааны тогтмол шугам нээхээр тохиролцжээ. Тэгэхдээ хоёр орны хооронд бүр 1992 оноос эхлэн агаарын харилцаа нээгдсэн бөгөөд 1993 он гэхэд Монголын иргэний агаарын Тээвэр (МИАТ)-ийн нисэх онгоц 20 удаа чартерийн нислэг хийсэн байснаас тодорхой байна. Тийнхүү 1994 оны 4-р сараас 10-р сар хүртэл ийм нислэг 30 удаа хийжээ. 1996 оны 4-р сарын сүүлчээс эхлэн Улаанбаатар—Осако хотуудын хооронд тогтмол нислэг хийж эхлэв. Энэ нь тус хоёр орны хоорондын харилцаа, хамтын ажиллагааны нэгэн тод илрэл тедийгүй цаашдын хөгжлийн нэгэн чухал хүчин зүйл болов.

Үүний хамт Японы янз бүрийн байгууллага, сайн дурын нийгэмлэг, пүүс компани. хувь хүмүүсээс Монголын олон арван байгууллага. хувь хүмүүс, хамт олонд төрөл бүрийн хэлбэрийн хэдэн зуун сая иений үнэтэй (хүмүүнлэгийн) тусламж ирүүлж буйг онцлон дурьдалтай. Тэдгээрийн тоо хэмжээг энд тооцож баршгүй

Зөвхөн нэгэн жишээ дурьдахад 1996 оны дөрөв тавдугаар сард Монголын ойт хээрийн олон нутагт түймрийн аюул учирсан байгалийн гамшгийн үеэр Японы орон нутгийн болон иргэний янз бүрийн байгууллага тухайлбал Хёго, Сайтама муж, усан онгоц хөгжүүлэх нийгэмлэг (НИППОН САН), Кобэ хотын засгийн газрын бус байгууллага зэрэг олон арван байгууллага, хэдэн мянган иргэдээс төрөл бүрийн хэлбэрийн тусламж (мөнгөөр тооцоолбол бараг 200 мянган ам. доллартай тэнцэх хэмжээнд хүрч буй бөгөөд энэ тоо бол эцсийн дүн мэдээ биш юм) ирүүлж байсныг хэлж болно (10).

Монголд болон Япон улсад хоёр орны харилцаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сайн дурын, олон нийтийн, найрамдлын, соёлын зэрэг олон арван байгууллага, нийгэмлэг байгуулагдан ажиллаж байна. Тэдгээр нь тус тусынхаа шугамаар төрөл бүрийн хамтын ажиллагаа өрнүүлж. тодорхой үр дүнд хүрч байгааг онцлон тэмдэглүүштэй.

Түүнчлэн хоёр орны худалдааны эргэлт хурдан өсөж байна. 1995 оны байдлаар манай улс дэлхийн 56 улстай худалдаа хийж байгаа бөгөөд манай экспортын 18,7 хувь,

импортын 11 хувь Японд онгодож байна. Монголд ирж буй гадаадын жуулчдын 50—60 хувийг Японы жуулчид эзэлж байна.

Сүүлийн хэдэн жил эрчимтэй хөгжиж байгаа Монгол-Японы харилцаанд манай хоёр орны соёлын солилцоо, энэ салбар дахь хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлж, ач холбогдол нь өсөн нэмэгдэж байна.

Япон Улстай соёлын харилцаа тогтоох асуудлыг 1968 оноос эхлэн тавьж байжээ. 1974 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр хоёр улсын Засгийн газрын хооронд соёлын солилцооны нот бичиг солилцсон байна. Энэхүү нот бичгийн дагуу хоёр тал дадлага хийгчид, жүжигчид, эрдэмтэн, мэргэжилтэн, оюутан тамирчид болон соёлын салбарт ажиллаж буй бусад хүмүүс солилцох, эрдэм шинжилгээний ажил хамтран хийх, лекц, кино, үзлэг, уран бүтээлийн үзэсгэлэн зэрэг соёлын арга хэмжээ зохиох талаар хамтран ажиллахаар тохиролцсон байна. Энэ дагуу соёлын харилцаа ургашилж байв.

Харин 1990 оноос манай хоёр орны харилцаа шинэ агуулгаар баяжин, харилцааны шинэ үе шатанд шилжсэн юм.

1991 онд Японы соёлын өдрүүдийг манай оронд анх зохион байгуулсан нь Японы түүх. соёл, зан заншил, нийгэм, эдийн засгийн өнөөгийн хөгжилтэй манай ард түмнийг өргөнөөр танилцуулсан анхны томоохон арга хэмжээнүүдийн нэг болсон гэдгийг энд дурдах хэрэгтэй юм.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлүүдийг даван туулахад Японы Засгийн газар, ард түмний үзүүлж байгаа улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн тусламж, дэмжлэг нь манай орны хувьд чухал ач холбогдолтой хүчин зүйл нэгэнт болж байгааг дээр тодорхой өгүүлсэн билээ.

Анх 1980 онд Японы Засгийн газрын цалингаар Японы их, дээд сургуульд суралцуулахаар оюутан хүлээн авсан цагаас хойш 1990 оны хүртэл жил бүр 2 оюутан авдаг байсныг жил бүр 5 оюутан хүртэл нэмэгдүүлээд байгаа бөгөөд цаашид энэ тоо өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ техник мэргэжлийн коллеж, мэргэжлийн дунд сургууль болон Японы соёлын солилцооны сан зэрэг байгууллагын шугамаар суралцагсдын тоо нэмэгдсээр байна.

Японы Засгийн газрын харъяа Японы Олон улсын хамтын ажиллагааны Агентлаг (ЖАЙКА)-ийн шугамаар зохиогддог үндсэн сургалтад манай улсаас төрөл бүрийн мэргэжлээр хүн сургаж байгаагийн зэрэгцээ тусгайлан Монголд зориулсан болон манайд хэрэгжүүлж байгаа төслүүдийн хүрээнд сургалтуудыг зохион байгуулж, эдгээр сургалтад хамрагдаж байгаа хүмүүсийн тоо, мэргэжлийн чиглэл жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Зөвхөн 1995 онд энэ сургалтанд нийт 97 хүн хамрагдаж байгаа тоо гарч байна. Үүний зэрэгцээ Японы ГХЯ, ЖАЙКА-гийн шугамаар 3 жил дараалан жил бүр 10—20 хүн Японд айлчилж, Японы өнөөгийн нийгэм, эдийн засаг, соёл, урлаг, зан заншил, хүн ардын аж амьдралтай танилцаж байна.

Манай улс Япон улсын Засгийн газрын соёлын буцалтгүй

тусламжийг 1984 оноос жил дараалан авч байгаа бөгөөд 1992 онд 50 сая иенийн үнэ бүхий монгол бичгийн компьютер, 1993 онд 46 сая иений лингофоны кабинет (ГХДС), 1994 онд 49 сая иений үнэ бүхий дуу, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж (УДБАТ)-ийг тус тус аваад байна (11).

Эдгээр тусламжийг зүй зохистой ашиглахын зэрэгцээ шинжлэх ухаан, техник өндөр хөгжсөн Япон улсын тэргүүний техник технологи. шижлэх ухааны ололтоос хичээнгүйлэн суралцаж, түүнийг өөрийн оронд нэвтрүүлэхэд анхаарч, энэ чиглэлээр Японтой үр бүтээлтэй хамтран ажиллах явдал бидний хувьд чухлаар тавигдаж байна.

Тийнхүү эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол, Японы харилцаа нь түүхийн янз бүрийн үед ээдрээтэй замыг туулсан бөгөөд эдүгээ Жинхэнэ зөв гольдорлогодоо орж байгаа онцлогтой байна. Үүний хамт энэ харилцаа цаашид улам гүнзгийрэн хөгжих өөдрөг ирээдүйтэй юм. Чухам үнэн хэрэгтээ Монгол—Японы харилцааг улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бусад салбарт тал бүрээр идэвхтэй хөгжүүлэх нь Монгол орон ардчилал, зах зээлийн замаар туйлбартай урагшлах. дэлхийн бусад орон, олон улсын байгууллагуудтай өргөн харьцаа тогтоож хамтран ажиллах, түүний олон улсын нэр хүндийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөлгөө.

---

* 1. С. Дамбадаржаа. Өгөөжтэй хорин жил «Дорно—орно», сэтгүүл. 1992. №1.
2. Мөн тэнд
3. Мөн тэнд
4. Гадаад харилцааны төв архив. ф—58. хн.12.
5. С. Дамбадаржаа. Өгөөжтэй хорин жил «Дорно—орно» сэтгүүл 1992. №1.
6. Ч. Улаан. Монгол—Японы хамтын ажиллагаа: эрт, өдгөө, ирээдүй «ЗГМ», 1995.07.19. №83.
7. Мөн тэнд
8. «ЗГМ», 1995.12.19. №189.
9. «АЭ» 1995.12.18. №200.
10. «ЗГМ», 1996.05.08. №85.
11. «ЗГМ», 1995.12.19. №189.

Scanned with CamScanner